



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/96

Ховд

“Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийн  
багийн бүрэлдэхүүн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийн, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төсөл арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх гүйцэтгэлийн хяналт хийж ажиллах төслийн багийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.


2. “Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийг ард иргэдэд сурталчлан таниулж, төсөл арга хэмжээний ажлын тоо хэмжээ, зураг төслийг хянаж, ажлын гүйцэтгэл явцын хяналт хийж гарсан зөрчлийг тухай бүр арилгуулж, ашиг сонирхлоос ангид байж захиалагчтай хамтран ажиллахыг “Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийн багт үүрэг болгосугай.

3. “Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийн багийн гишүүдийн цалингийн хэмжээг Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 6 дугаар жагсаалтын 2 дахь заалт Нягтлан бодогч, программист, сүлжээний инженер, хуулийн зөвлөх, архитекторч, технологичтой жишиж (ТҮ-7-5) цалингийн сүлжээгээр тогтоон 2 дугаар хавсралтаар баталсугай.


4. “Хашаандаа сайхан амьдарцгаая” төслийн багтай гэрээ байгуулан, сар бүр Улсын төсвийн тухай хуулийн XII.1.27 дахь заалт Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Ховд аймаг, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/ төсөл арга хэмжээний техникийн хяналтын зардлаас санхүүжүүлэн цалинжуулахыг аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадрал, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого

төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

5. "Хашаандаа сайхан амьдарцгаая" төслийн багийг өдөр тутамд удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Засаг даргын орлогч Т.Жаргалсайханд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ





Аймгийн Засаг даргын 2022 оны  
02 дугаар сарын 25-ны өдрийн  
А/96 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт

“ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЦГААЯ”  
ТӨСЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

1. Гишүүн - Б.Сумхүү
2. Гишүүн - А.Чимэгмаа

Аймгийн Засаг даргын 2022 оны  
02 дугаар сарын 25-ны өдрийн  
А/96 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт

ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЦГААЯ ТӨСЛИЙН  
БАГИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ /12 сар/

					Төгрөгөөр/
Д/д	Хариуцах ажил	Овог нэр	Цалингийн хэмжээ	Урамшуулал	12 сар ажиллах
1	Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн гишүүн	Б.Сумхүү	766481	20 хүртэлх хувь	11037324
2	Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн гишүүн	А.Чимэгмаа	766481	20 хүртэлх хувь	11037324
Нийт					<b>22074648</b>

Жич: Ажлын үр дүн гүйцэтгэлээр цалингийн 20 хүртэл хувиар тооцож сар бүр урамшуулна.

-оОо-